



ХЭҮК



НУБХЭДКГ



ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХИЙН ЭРХ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

ҮНДЭСНИЙ ЦӨӨНХИЙН ЭРХ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар
2005 он

UIH.MN
БУДАЛГААНЫ САН

Цаасны хэмжээ: 60х90/16
Хэвлэлийн хуудас: 4
Хэвлэх тоо: 500 ш
“Согоо нуур” ХХК-д хэвлэв.

Гарчиг

Оршил.....4

Бүлэг 1: Түүхэн уламжлал

- 1.1 Цаатан гэж хэн бэ?8
- 1.2 Цаатан ард түмний талаар 1990-ээд оноос өмнө авч хэрэгжүүлж байсан арга хэмжээ9
- 1.3 Цаатан иргэдийн амьжиргааны өнөөгийн дүр төрх11

Бүлэг 2: Өнөөдөр цаатан иргэдийн талаар авч хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэр

- 2.1 Эрх зүйн орчин14
- 2.2 Цаатан иргэдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ.....15

Бүлэг 3: Цаатан иргэдийн үндэстний цөөнхийн эрх болон бусад эрхийн хэрэгжилтийн төлөв байдал

- 3.1 Үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт19
- 3.2 Цаатан иргэдийн эдийн засаг, нийгэм соёл, иргэний, улс төрийн эрхийн төлөв байдал22

Дүгнэлт29

Хавсралт 1: Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос Хөвсгөл аймгийн ИТХТ-ийн дарга, засаг дарга, Цагааннуур сумын засаг дарга, ИТХТ-ийн дарга нарт хүргүүлсэн зөвлөмж30

Хавсралт 2: Хүний Эрхийн Үндэсний Комиссоос судалгааны мөрөөр авч буй арга хэмжээ.....32

ОРШИЛ

Улс орнуудад арьсны өнгө, хэл, шашин шүтлэг, үндэс угсаа, яс үндэс, бэлгийн чиг баримжаагаараа ялгаран нийгэмтээ дийлэнх болдоггүй бүлэг хүтүүсийг цөөнх хэмээн ерөнхийд нь тодорхойлдог. НҮБ-ын ивээл доор олон улсын хаттын нийгэмлэг цөөнхийг халгаалах зорилгоор цөөнхийн эрхийн стандартыг томъёолж эхлээд байна.

Аль ч улсын хувьд олонх цөөнхүүд хоорондоо зохицон амьдрах явдлыг чухалчлан үздэг. Ийнхүү зохицон амьдрах үндэс нь хүн бүр эрх, эрх чөлөөгөө аливаа төрлийн ялгаварлал, тэгш бус байдалгүйгээр эдлэх нөхцөлд бүрдэх нь ойлгомжтой. Энэ үзэл санаа нь Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын оршилд "Хүн төрөлхтөний гэр бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салиггүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс төнийг иш болгон," хэмээн томъёологдсон байдаг билээ. Тиймээс цөөнхийн тухай асуудлыг онцгойлон авч үзэж байгаа нь ардчиллын нэг чухал хэлжүүр болох нь дамжиггүй. Цөөнхийн хувьд олон төрлийн томъёолол байж болох авч энэ дундаас үндэстний цөөнхийн тухай асуудлыг авч үзэж судлах нь хүний эрхийн салбарт чухал ач холбогдолтой юм. Эндээс үндэстний цөөнх гэж хэн бэ, үндэстний цөөнхийн эрхийг олон улсын эрх зүйд болон дотоодын эрх зүйд хэрхэн авч үзэж, хангаж, халгаалсан, энэ чиглэлээр ямар техниктууд байдаг вэ зэрэг олон асуудал урган гарч ирнэ. Үндэстний цөөнхийг тодорхойлоход олон бэрхшээлүүд тулгардаг. Жишээ нь зарим үндэстний цөөнх нь бие даасан автономн эрхтэй байхад зарим нь амьдарлын хэв таяг, хэл, соёлоо хадгалан аж төрсөөр байдаг, түүнчлэн зарим бүлгийнхний хувьд улс орны тодорхой газар нутагт оршин тогтнож байдаг бол зарим цөөнхийн хувьд тархай бутархай амьдарч байх, зарим нь түүх, соёлоо хадгалан, халгаалж цаасан дээр буулган авч үлдсэн байхад, нөгөө хэсэг нь амнаас ам дамжсан дотог хэлбэрээр хадгалж үлдсэн байх, мөн түүнчлэн түүхийн урт хугацааны явцад тухайн улсын хүн амын дийлэнх бүлэгт ууссан зэрэг бэрхшээлүүдийг дурьдаж болно.

Үндэстний цөөнхийн эрхийн тухай асуудлыг тусгасан олонх гэрээ конвенцийг Монгол улс соёрхон баталсан. Тухайлбал Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (27), Эдийн засаг, нийгэм,

соёлын эрхийн тухай олон улсын Пакт (13), Арьс, үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (2, 4), Хүүхдийн эрхийн тухай Конвенц (30), Боловсролын талаар алагчилахтай тэлцэх тухай Конвенц (5), Төрлөөр устгах гэлт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм хэрэг үйлдэгчдийг шийтгэн цэрлүүлэх тухай Конвенц (2) зэргийг дурьдаж болох юм. Монгол улс дээрх гэрээ конвенцийн гишүүн орны хувьд үндэстний цөөнхийн эрхийг хангах, хамгаалах талаар томоохон үүрэг, хариуцлага хүлээж байгаа юм. Түүнчлэн зарим гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хянах Хороонд үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар тайлагнах үүргийг танай Засгийн газар хүлээсэн байдаг.

Олон улсын гэрээ, конвенциудад үндэстний цөөнхийн эрхийг хангаж, хамгаалах, хөхиүлэн дэмжихэд ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш байх зарчмыг төрдлөг болгохыг чухалчлан заасан байдаг. Ихэнх улс орнууд хууль тогтоомждоо ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг тусгасан байдаг ч хуулийг хэрэгжүүлэх шатанд үндэстний цөөнхүүд ялгаварлагдах байдал элбэг байдаг. Аливаа улс үндэстний цөөнхийн эрхийг хэрхэн хангаж, хамгаалж байгаа нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын хүрээнд үндэстний цөөнхийн эрхийн асуудлыг ямар түвшинд авч үзэж, асуудлыг нь хэрхэн шийдвэрлэж буй байдлаар тодорхойлогддог. Тиймээс үндэстний цөөнхийн эрхийг хангаж, баталгаажуулах нь зөвхөн хууль тогтоомжид зааж өгөх төдийгөөр хязгаарлагдах зүйл биш. Үүний тулд үндэстний цөөнхөө зөв тодорхойлж, томъёолох ёстой бөгөөд бид нэг тодорхойлолтыг онцлон авч үзсэн болно. Үндэстний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах, өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзлэл бүхий тодорхой бүлэг хүмүүсийг хэлнэ.¹ Аливаа улс дотооддоо байгаа үндэстний цөөнхийн эрхийн хамгаалал ямар байгаа талаар судалгаа, шинжилгээ хийж, засан сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах шаардлагатай билээ. Тэгвэл манай улсын хувьд үндэстний цөөнхүүд байдаг уу, байдаг бол ямар бүлгийг үндэстний цөөнхөд тооцдог вэ гэсэн асуулт гарч ирнэ. Монгол улс 1969 онд нэгдэн орсон Арьс үндсээр алагчилах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийн талаар НҮБ-ын Арьс Үндсээр Алагчилах Үзлийг Устгах Хороонд нийт 11 удаа тайлан тавьсан байх бөгөөд энэ бүх хугацаанд Монгол улсын үндэстний цөөнх бол ганцхан казак үндэстэн хэлтээн үзэж иржээ. Дээрх илтгэлүүдэд Монгол улсад 25 хүртэлх үндэстний цөөнх, угсаатны цөөнх амьдарч байгаа

¹ Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага, Х.Виктор Кондэ, 102 дахь талд

хэлээсэн ч зөвхөн казак иргэдийг үндэстний цөөнх хэлээн тодорхойлсон бөгөөд үндэслэл нь өөрийн хэлтэй, бусад цөөнхүүд тонгол хэлээр өөрсдийн нутгийн аялгуугаар ярьдаг хэлээн үзсэн тэй холбоотой ажээ. Харин 2004 онд хэвлэгдсэн Монгол Улсын түүх, соёл иргэншлийн атласт Монгол Улсын нутаг дэвсгэр дээр түрэг угсааны казак, тува, хотон, чантуу хэлээх үндэстний цөөнх болох бүлэг хүтүүс оришдог хэлээн үзжээ. Гэсэн хэдий ч одоог хүртэл Монгол улс хичнээн үндэстний цөөнхтэй вэ гэдэг асуулт тодорхой хариултгүй явж ирсэн. Ер нь үндэстний цөөнхийг угсаатны цөөнхөөс ялгавартай авч үзэх шаардлагатай юм. Энэ нь тухайн бүлгүүдэд тусгай зохицуулалт шаарддагтай холбоотой. Энэ асуудлыг тодорхой болгох нь төрөөс үндэстний цөөнхийн эрхийг хангах, халгаалах чиг үүргээ бүрэн төгс хэрэгжүүлж эхлэх анхны алхам билээ. Дээрх тодорхойгүй байдал нь зарим үндэстний цөөнхийн асуудлыг орхигдуулах, эрхийг нь зөрчигдөх байдалд хүргэж байна.

Тийт ч учраас Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2003 онд НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын санхүүжилтээр Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутаг дэвсгэрт альдарч байгаа урианхай² буюу цаатан хэлээх цөөнх иргэдийн эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг судлав.

Өнөөдөр цаатан иргэдийн тухай олон нийтийн мэдлэг хангалттай биш, мэдлэгтэй гэж үзэж байгаа хэсгийн хувьд тэднийг үл тоох хандлага илүүтэй давалгайлах болсон байна. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулах төслийн хүрээнд 2001 онд хийгдсэн. Хүний эрхийн төлөв байдлын судалгаанд³ цаатан иргэдийн эрхийн талаар хураангуй мэдээ оруулсныг эс тооцвол сүүлийн жилүүдэд цаатан иргэдийн талаар анхаарч судалсан судалгааны ажил байхгүй байна.

Цаатан хэлээн нэрийдсэн эдгээр бүлэг хүтүүс нь өөрийн хэл, соёл, шашин шүтлэгээрээ тонголчуудаас ялгарч буй бөгөөд үндэсний цөөнх болох нь тодорхой юм. Комиссоос үндэсний цөөнх болох цаатангуудын эрхийн асуудлыг судлахдаа өөрийн соёл иргэншилээ хадгалж үлдэх, өөрийн шашныг шүтэх, төрөлх хэлээрээ ярих эрхээр хэрхэн хангагдаж байгааг онцлон авч үзсэн болно. Эдгээр цөөнх нь “Тува”, “Урианхай”, “Духа” гэх тэтээр ялгагддаг боловч судалгааны тайланд “Цаатан” хэлээн нийтэд түгэсэн нэрээр нь авсан болно.

СУДАЛГААНЫ САН

² С.Бадамхатан, Хөвсгөлийн цаатаг угсаатан, 1960 он, 27 дахь талд

³ Монгол улс дахь хүний эрхийн тө. эв байдал, 2001 он, 128 дахь талд

Судалгаанд хамрагдсан хүрээ

Хөвсгөл айлгуйн Цагааннуур сумын⁴, тус сумын нутаг дах баруун, зүүн тайгад амьдарч байгаа цаатан иргэдийг хамруулан хийсэн. Мөн түүнчлэн Улаанбаатар хотод сурч байгаа цаатан гарлын оюутнууд, Цагааннуур сумын дунд сургуульд суралцаж байгаа дунд сургуулийн сурагчдыг оролцуулсан. Түүнээс гадна тал таллан амьдарч байгаа болон сумын төвд амьдардаг нэн ядуу, ядуу цаатан иргэд, сумын сургуульд багшилдаг цаатан гаралтай иргэдийг оролцуулсан. Анкет-сурвалжлагын аргаар нийт 37 цаатан иргэд буюу тайгад амьдарч байгаа насанд хүрсэн иргэдийн 50 орчим хувьд судалгаа авсан. Ганцаарчилсан ярилцлагыг нийт 30 хүнтэй хийсэн. Цагааннуур сумын дунд сургуулийн багш нар, Улаанбаатар хотод их дээд сургуульд суралцаж байгаа цаатан оюутнууд, цаатан, цаа буга судалдаг судлаач, эрдэмтэд болон цаатны төлөөлөл оролцсон нийт 3 бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан юм. Түүнчлэн Хөвсгөл айлгуйн төв Мөрөн хот болон Цагааннуур сумын Засаг даргын Талгуйн газар, холбогдох хэлтэс, албад дээр цаатангын талаар гаргасан шийдвэр, хүн амын болон талын тоо бүртгэл зэрэг баримт бичгийн судалгаа хийв. Судалгааны ажлын явцад цаатан иргэдэд чиглэсэн арга хэлжээ, хөтөлбөр, төслүүдтэй танилцлаа.

Судалгаа хийсэн аргачлал

Судалгааг баримт бичигт дүн шинжилгээ хийх, анкет-сурвалжлагын арга болон бүлгийн ярилцлага хийх, сурвалжлага хийх, урьд өтнө нь цаатангуудтай холбоотой хэвлэгдсэн ном, товхимол, судалгааны материалтай танилцах гэх тэт арга барилаар явуулсан.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

⁴ Монгол улс нь засаг захиргааны нэгжийн хувьд аймаг (нийтдээ 21 аймагтай), аймаг нь сумдад хуваагдана.

1.1. Цаатан гэж хэн бэ?

Манай улсын умар зүгийн ой тайгад цаа буга маллаж амьдардаг хэсэг ардыг, ардын хувьсгалаас хойш манай утга зохиол, ярианы хэлэнд Цаатан гэж нэрлэх боллоо. Хувьсгалаас өмнө нийтэд нь Тагна урианхай гэж нэрлэдэг байсан боловч тайгын иргэд, Соёд урианхай гэж ялгах явдал ч байжээ.⁵ Ийнхүү цаатан хэмээн нэрийдсэн нь тэдгээр бүлэг хүмүүсийг онцлож, ахуйн шинжээр нь тодотгосон байна. “Цаатан” гэдэг үг нь цаа бугатай хүн гэсэн утгыг илэрхийлнэ.

Хөвсгөл аймгийн Цагаан нуур сумын хоёрдугаар багийг бүрдүүлж байгаа цаа маллан тайгад амьдардаг уйгур угсааны тува /Духа/ хүмүүс нь Монгол Улсын үндэстний хамгийн цөөнх болно. Эдгээр хүмүүс нь ОХУ-ын Тувагийн нутаг хуучин Тожийн хүшуу, Тоду, Соён Кыргыз, Ханачи, Маат, Балыкчи, Хуулар овгийн Тува яс угшлын хүмүүс юм. Монголд ойн иргэд цаа буга өсгөн маллаж, хонь малладаг малчидтай зөрчилдөж байдаг тухай Ираны түүхчид 1310 оны үед бичсэн байдаг.



Баруун тайгад амьдардаг цаатан хүүхдүүд

Цаатан иргэд нь Улаанбаатар хотоос 1000 гаруй, Хөвсгөл аймгийн төвөөс 300 гаруй, Цагааннуур сумын төвөөс 50-70 км алслагдсан, өндөр ууланд амьдардаг. Тэдний амьдардаг газар нь дэлхийн бөмбөрцгийн хойт өргөргийн 52°-60°, уртрагийн 98°-102° хоорондох зайд орших Монгол улсын нутаг дэвсгэрийн хөвдөн

⁵ С.Бадамхатан, Хөвсгөлийн цаатан угсаатан, 1960 он, 3 дахь талд

бэлчээртэй, ян сарьдаг уулууд юм. Энд өвлийн улиралд цельсийн хасах 29-53 хэм хүртэл хүйтэрч, зуны улиралд цельсийн нэмэх 12-23 хэм хүртэл дулаарна. Жилийн дундаж хур тунадас нь 320мм хүрдэг. Уул нуруунууд нь далайн түвшнээс 2500-3500 метр өндөрт өргөгддөг, эрс тэс уур амьсгалтай.

1.2. Цаатан ард түмний талаар 1990-ээд оноос өмнө авч хэрэгжүүлж байсан арга хэмжээ

ОХУ-ын Автономит Тува болон Монголын хил залгаа аглаг их тайгад дураараа нүүдэллэн цаа маллаж, ан аваар амьдарч байсан 53 өрх иргэдийн хүсэлтийг харгалзан 1955 онд Монгол улсын иргэн болгожээ. Цаатан ардын аж төрлийн байдал, зан заншлын талаар хамгийн ултай судалгаа явуулсан эрдэмтэн С.Бадамхатангийн дурдсанаар 1960 оны байдлаар нийт 574 цаа бугатай 30 цаатан өрх бүртгэгджээ. Түүнээс хойш цаатан ардууд монгол улсын иргэний ёсоор өөрсдийн малладаг цаа бугынхаа ашиг шим, ан авын өгөөжөөр амьдарч байгаад нэгдэлжих хөдөлгөөний үед цаагаа нийгэмчилжээ. Тэдний амьдралыг дээшлүүлэх, сурч боловсроход нь туслалцаа, дэмжлэг үзүүлэх зорилгоор тэр үед төрөл бүрийн арга хэмжээ авдаг байжээ.

Юуны түрүүн тэднийг тайгын бөглүү амьдралаас ангижруулж төвд суурьшуулан байшинд амьдруулах гэсэн оролдлого хийснээс эхлээд тэдэнд зориулж цаа бугын болон загас, ан агнуурын аж ахуй буй эрхэлж хамт олноороо хөдөлмөрөө хоршин амьдрахад чиглэгдсэн алхам хийгдэж, Цагааннуур сумыг шинээр байгуулжээ. Загас, ан агнуур, цаа буга өсгөх төлөвлөгөө өгч цалин хөлс олгон ажилуулж байв. Цаатан ардуудыг суурьшуулах талаар тэр үед хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан байна.

Цаатан хүмүүс анх Хөвсгөл аймгийн Улаан-уул, Рэнчинлхүмбэ сумын нутагт харьяалагдаж амьдарч байжээ. 1950-аад оны үед Улаан-Уул сумын намын хорооноос цаатан ардуудыг суурин амьдралтай болгох, тайгаас буулгаж ирэх зорилт тавьж тэдэнд зориулан байшин барьж, цаа бугынх нь хоол болох хөвд ургамлыг нь ой тайгаас машинаар зөөж, цаатангуудыг тайгад нь буцааж явуулахгүй барьж байхын тулд харуул манаа хүртэл гаргаж жил орчим байлгаж байжээ. Гэтэл цаатангууд, цаа буга аль аль нь гундаж, өвчин эмгэг тусах, хөвд ургамлыг нь олж ирэхэд маш их зардал гаргах зэргээс үүдээд Намын Төв Хороонд⁶ уламжилж тэдгээр цаатан ардуудыг тайгад нь буцааж байжээ.

⁶ Тэр үед Монголд намын байгууллага нь төр, аж ахуйн ажилд шууд хутгалдан орж, бодлогын шийдвэр, чиглэлийг гаргадаг байв.

Үүнээс хойш 1956 онд Цагаан нуурт загасны үйлдвэр барих үеэр дахин цаатан ардуудыг суурьшуулах ажил хийгдэж эхэлсэн. Энэхүү загасны үйлдвэрийн гол ажилчдыг цаатангуудаас бүрдүүлэх бодлого барьж байжээ. Үйлдвэрийн анхны дарга байсан Батаа "...Тэр үед цаатангуудыг загасны үйлдвэрт авч ирж ажиллуулах гэж маш их ажил болдог байсан. Анхны өрх бол Намжилсүрэн гэдэг 4 хүүхэдтэй цаатан эмэгтэй үйлдвэрт ажил хийх болсон. Тэрнээс хойш ихэвчлэн залуучууд нь ажиллах болсон. ...Тэд бол их хөдөлмөрч, цаг агаарын хүйтэнд тэсвэртэй сайн ажиллах хүч байсан...Нам засгаас тэдэнд маш их анхаарал тавьж тэдэнд зориулж тус бүр нь 2 өрөө бүхий 30 байшин барьж өгсөн. Мөн жижиг цахилгаан станц, радио, хүүхдийн цэцэрлэг, ясли, бага сургууль зэргийг Цагааннуурт байгуулж өгсөн..." гэж ярьсан⁷ юм. Тэр үед загас агнуурын аж ахуйд тайгын цаатан залуус бараг бүгдээрээ ажиллан загасчин болж хэдхэн хөгшчүүл тайгадаа амьдарч байв. ОХУ-ын Астерхань хотод загас агнуурын мэргэжил эзэмшсэн Дашдоржийг 1970 онд ирэхэд тайгад О.Цэвэг, Эрэгсэл, Жамбадорж, Гомбосэд, Самдан, Эрэнцэн, Чаришхан нарын 7 өрх л үлдсэн байв.⁸ Энэ нь залуусыг зохион байгуулалттайгаар ажилчин болгож байснаас болж их тайга эзгүйрч цаатан цөөнхийн хувьд устаж үгүй болоход хүрсэн үе байв. Дээр нэр дурдсан цаатан ардууд бол өөрсдийн уламжлалт зан үйл, хэл соёл, цаатай холбоотой нүүдэл суудал, аж төрлийн хэвшлээ хуучнаар нь хадгалж ирсэн хүмүүс байжээ. Энэ хүмүүсээс эрдэмтэн С.Бадамхатан, профессор О.Сүхбаатар, доктор Ж.Саруулбуян, судлаач Г.Аюурсэд нар цаа буга, цаатангийн тухайд сонирхолтой судалгааны материал цуглуулжээ.

Социалист системийн жилүүдэд Монголын цаатан ардууд нийгэмд хөдөлмөр эрхлэх, ан авыг төлөвлөгөөтэй авлах, цаагаа эрүүлжүүлэх, үүлдэр угсааг сайжруулах нь тодорхой бодлогоор зохицуулагдаж байв. Хоёр удаа 1000 цааны баяр ёслол тэмдэглэсэн түүхтэй. Энэ цаг үед цаатангуудад өвлийн дулаан хувцас олгох, өндөр настнуудыг үнэгүй хооллох, тайгад амьдарч байгаа өндөр настнуудад тэтгэвэр олгох зэрэг ажил хийгдэж байжээ. Түүнээс гадна цаатан боловсон хүчнийг бэлтгэх бодлого барьж, ОХУ-ын Автономит Тувад явуулж сургаж байжээ.

Тэр үеийн Парламент болох Ардын Их Хурлын дэргэдэх Залуучууд, Үндэсний Асуудлын Комисст үндэсний цөөнхийн асуудлаар тусгайлан судалгаа хийдэг ажилтныг ажиллуулж, цаатангууд дээр жилд тодорхой

⁷ Д.Батаагийн ярианаас

⁸ Л.Дашдоржийн ярианаас

хугацаагаар очих томилолтыг төсвөөс гаргаж, тэдний амьдралын түвшин, боловсрол, эрүүл мэндийн байдал, хөдөлмөр эрхлэлт, соёл урлаг гэх мэт зүйлсийн талаар Комисст мэдээлэл, тайлан бичиж өгдөг байжээ. Энэ нь үнэн бодит мэдээллийг төрийн удирдлагад өгөх, энэ дагуу ажил зохион байгуулахад тус дөхөм болж байв. Тухайн үед цаатангийн талаар авч байсан зарим арга хэмжээг дурьдвал:

- | | | |
|------------|---|--|
| 1. 1956 он | СнЗ 84-р Тогтоол | Загасны үйлдвэр байгуулах тухай |
| 2. 1972 он | СнЗ 331-р Тогтоол | Улсын ан, агнуурын аж ахуй байгуулах тухай |
| 3. 1982 он | УАААА-г татан буулгасан. | |
| 4. 1985 он | АИХ-ын Тэргүүлэгчдийн 245-р зарлигаар Цагааннуур сум байгуулагдсан. | |
| 5. 1985 он | СнЗ 26-р Тогтоол | Ан агнуур, цаа бугын аж ахуй байгуулах тухай |

1.3. Цаатан иргэдийн амьжиргааны өнөөгийн дүр төрх

1990-ээд оны үеэр цаатангуудад цааг нь хувьчлан өгч, урьд өмнөх тодорхой бодлого, үйлчилгээ үгүй болсноор тайгынхны амьдрал эрс хүндэрч, цаагаа олноор нядлах, цааны эврээ худалдах, ангын олзоор амьдрах зэрэг өнөө маргаашаа өнгөрөөн аргацаах байдалд шилжжээ. Цааны эврээ жил бүр хөрөөдөн авч амьдралаа залгуулсаар байгаа нь цааны өвчин ихэсэхэд хүргэж буй бөгөөд цаа бугын үржил багасан, ерөнхийдөө жижгэрч, давжаарч ирсэн юм. Мөн загас агнуурын аж ахуй татан буугдаж тэнд ажиллаж байсан цаатан иргэд эргэн тайгадаа гарснаар тайгын хүн ам ихэсч, цаа цөөрөх хандлага руу оржээ. Мөн түүнчлэн цааг хувьчлахдаа цаа бугын аж ахуйд үржлийн цааг авч үлдээгүй, цаа бугыг нэгэнт хувьчилсан гэдэг шалтгаанаар эрүүлжүүлэх болон бусад үржил селекцийн асуудалд анхаарал тавихаа больсон зэрэг хүчин зүйл цаа бугыг хорогдоход их нөлөөлсөн.

2002 онд Цагааннуур суманд амьдарч байгаа цаатан иргэдийн судалгааг гаргажээ. Тус сумын 2 багт нийт 114 өрхийн 493 цаатан хүмүүс амьдарч байна. Хүйсийн хувьд 240 эрэгтэй, 255 эмэгтэй байна. Тэдгээрийн 39,9%-ийг 0-16 насны хүүхдүүд, 19,8%-ийг 17-25 насны залуучууд, 20,2%-ийг 26-35 насны хүмүүс, 15,2%-ийг 36-60 насны хүмүүс, 4,6%-ийг 60-аас дээш насны ахмадууд эзэлж байна.

No	Байршил	Өрх	Хүн	Үүнээс		Цаа	Монгол мал
				Эр	Эм		
1	Баруун тайга	22	110	51	59	385	427
2	Зүүн тайга	20	97	46	51	178	167
Бүх дүн		42	207	97	110	563	594

Тайгын багийн засаг даргаас авсан мэдээгээр баруун тайгад 2002 онд нийт 385 цаа буга тоологдсон бол 2003 оны 8-р сард Улаанбаатараас очсон эрдэмтдийн тоолсноор баруун тайгад 512 цаа буга байсан байна. Ер нь цаа бугын жинхэнэ тоог гаргахад бэрхшээлтэй. 1990 онд 1000 цааны баяр тэмдэглэхэд цааны тоо толгой 1000 хүрээгүй байсан гэж мэтгэлцэх хүн ч байдаг. Цааны жинхэнэ тоо толгойг хэлдэггүй нь цаатнуудын сүсэг бишрэлтэй холбоотой ажээ.



Уналаганд хэрэглэдэг цаа буга

2002 оны байдлаар баруун зүүн тайгад амьдарч байгаа нийт 42 өрх айлд 563 цаа тоологдсон гэж үзвэл нэг хүнд дунджаар 2.7 цаа оногдох болжээ. Энэ онд тайгад 3 өрх шинээр нэмэгдэж 45 өрх болсон бөгөөд 210 хүн амтай болжээ.⁹

Өнөөдөр баруун зүүн хоёр тайгад амьдарч байгаа цаатан ардуудын дунд хуучин уламжлал, зан заншил, соёлоо нарийн мэдэх хүн бараг үлдсэнгүй. Шашин, зан заншлынх нь уламжлал, өвөрмөц хэв хэвшил ч дархадын¹⁰ соёлоос ялгарахаа больжээ. Манай хүн амын цөөнх болсон

⁹ Тайгын багийн дарга Г.Буянтогтохын гаргасан мэдээгээр

цаатан хүмүүсийн хэл, соёл, зан заншил, шашныг хуучин хэвээр нь хадгалан үлдээх бодит боломж нөхцөл ихээхэн хязгаарлагдмал байгаа бөгөөд орчин үед энэ нь улам ч хумигдаж байгаа билээ.

Цагааннуур сумын тайгад амьдарч байгаа нийт 42 өрхийн 14 өрх буюу 33% нь нэн ядуу, 38% нь ядуу нөхцөлд амьдарч байна. Амьдралын хүнд нөхцөл, амьжиргааны эх үүсвэрийн хомсдол нь цаа бугаа өсгөн үржүүлэх, маллах, хайрлах уламжлалд нь ч сөргөөр нөлөөлөх болсон. Үүний тод жишээ бол цөөхөн цаатай зүүн тайгын иргэд цаа бугынхаа цусан эврийг нь толгой дараалан авсан байхад баруун тайгын арай боломжтой өрхүүд цаа бугынхаа цусан эврийг бараг аваагүй байсан явдал юм.

Цаатан иргэдийн дунд архидалт мэр сэр гардаг бөгөөд үүнээс үүдээд бие биенийхээ эрх чөлөөнд халдах, хүнд хөнгөн гэмтэл учруулах гэх мэт зөрчлүүд гардаг.

... Судалгаа хийх явцад нэг цаатан эмэгтэйн нүүр нилээд их гэмтсэн байсан бөгөөд учир байдлыг лавлахад нилээд нуусны эцэст манай хамаатны дүү архи уугаад ухаан нь балартсан байхдаа намайг зодсон, тэгэхдээ гомдолгүй гэж их л сандрангуй хэлж байсан...

Судлаачийн тэмдэглэл...

Үүнээс үүдээд бие биенийхээ эрх чөлөөнд халдах, хүнд хөнгөн гэмтэл учруулах гэх мэт зөрчлүүд гардаг бөгөөд энэ байдалд хүүхэд, хөгшид, эмэгтэйчүүд илүү өртөж, хохирох тал ажиглагдаж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁰ Монгол үндэстэн нь ястангуудаас бүрддэг бөгөөд дархад нь ястнууд юм.

БҮЛЭГ II. ӨНӨӨДӨР ЦААТАН ИРГЭДИЙН ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОДЛОГО, ШИЙДВЭР

2.1 Эрх зүйн орчин

Монгол улс 1969 онд Арьс, үндсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, 1991 онд нэгдсэн Хүүхдийн эрхийн тухай Конвенц, 1981 онд Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцид нэгдэн орсон ба бусад хүний эрхийн олон улсын гэрээ хэлэлцээрт үндэсний цөөнхийн эрхийн асуудал тусгагдсан тул Монгол улсын Засгийн газар үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах, хангах талаар томоохон үүрэг, хариуцлага хүлээж байгаа юм. Мөн түүнчлэн Монгол улсын Үндсэн хуулинд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”¹¹ хэмээн заасан. Бусад хуульд ч үндэсний цөөнхийг ялгаварлан гадуурхахгүй байх талаар тусгагдсан. УИХ-аас 2003 онд батлан гаргасан Монгол Улсын Хүний Эрхийг Хангах Үндэсний Хөтөлбөрт үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн хөгжүүлэх боломжийг сайжруулах, эх хэлээрээ мэдээлэл авах, түгээх боломжийг хангах талаар тусгайлсан заалтууд байдаг.

Дээрх хууль тогтоомж, хүний эрхийн олон улсын гэрээг хэрэгжүүлэхэд энэ чиглэлээр боловсруулан гаргасан эрх зүйн актууд чухал ач холбогдолтой юм. Цаатан ардуудын талаар болон тэдний аж амьдралыг дээшлүүлэх чиглэлээр дараах хоёр шийдвэр гаргажээ.

- 1993 он 968 цаа бугыг 83 хүнд түрээсэлсэн.
- 1995 он Засгийн газрын Өмч хувьчлалын комисс 275-р тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 422-р тогтоол, Аймгийн өмч хувьчлалын Комиссын 11-р тогтоолоор цааг иргэдэд хувьчилж өгсөн.

Харин цаатан иргэдийн талаар гаргасан өөр дорвитой бодлого, шийдвэр байхгүй байна.

¹¹ Монгол улсын Үндсэн хууль, 1992 он, 2-р бүлэг, 14-р зүйл

2.2 Цаатан иргэдийн асуудлаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

2.2.1 Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

1990 оноос хойш цаатан иргэдэд чиглэсэн нэг гол арга хэмжээ бол цаа бугыг хувьчилсан явдал юм. Гэвч ашиг шим ихтэй, бусад орны цаа бугыг бодвол бие томтой онцгой үүлдрийн цаа бугаа тоо толгойг нь бууруулахгүй байх, эрүүлжүүлэх, үржил селекцийг мэргэжлийн байгууллагын хяналтанд байлгах гэх мэт зүйлийг тооцоололгүйгээр хувьчлалыг явуулсан нь бодлогын хувьд алдаатай байсан. Тиймээс ч цаа бугын бие нь давжаарсан, цус ойртсон, бруцеллёз, анаплазмоз, арьсны болон хамрын хөндийн гуур зэрэг өвчинд нэрвэгдсэн байдалтай болжээ.

... Одоо цаа бугын талаар төрөөс ямар нэг арга хэмжээ авахгүй бол тахь нутагшуулсны нэг адил зардал чирэгдэл болоход хүрч бодзошгүй...

Малын эмч асан Аюурсэд

Социализмын үеэс төрөөс анхаарч байсан нэг зүйл бол цаатан боловсон хүчнийг бэлтгэх явдал байсан. Энэ хүрээнд дотоодын их дээд сургууль болон гадаадад явуулж сургаж байв. ОХУ-ын Автономит Тувад зарим цаатныг сургаж байсан. Цаатан ардуудын амьдралыг дээшлүүлэхэд цаа бугыг эрүүлжүүлэх, тоо толгойг нь өсгөхөд чиглэсэн арга хэмжээ шаардлагатай юм. 1970-аад оны үед Тувагаас хоёр ч удаа 70 гаруй цааг авчирч, цус сэлбэлт хийснээр цаа бугын тоо хамгийн олон буюу 2300 орчим тоо толгой болж байжээ. Сүүлийн үед орон нутгийн хэмжээнд болон гадны байгууллага, төрийн бус байгууллагууд цаа бугыг Тувагаас оруулж ирэх талаар ихэд хөөцөлдсөн ч өнөөдрийг хүртэл амжилтанд хүрэхгүй байна. Иймээс Монгол улсын эрх бүхий байгууллагаас, ОХУ-ын холбогдох байгууллагуудтай цаа буга оруулж ирэх талаар гэрээ хэлэлцээр хийх шаардлага тулгарч байна. Цагааннуур сумын 8 жилийн сургуульд Тува хэлийг урьд нь үзэж байсан уламжлалыг сэргээхэд холбогдох яам анхаарлаа хандуулах цаг болсон.

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооноос 2003 оны 8-р сард Монгол улсын Ерөнхий сайдад хандан цаатан иргэдийн амьдрал ахуйн өнөөгийн байдал, тугамдаж буй асуудлууд болон тохиолдож байгаа бэрхшээл, цаа бугын сүргийг өсгөн үржүүлэх, хамгаалах талаар цаатан иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг судлан үзэж, дээрх асуудлаар Монгол улсын Засгийн газар ямар бодлого баримталж байгаа тухай мэдээлэхийг хүссэн албан тоот илгээжээ. Засгийн газар одоо энэ асуудлыг судалж байгаа юм байна.

2.2.2 Орон нутгаас авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэтжээ

Одоогийн байдлаар орон нутгаас цаатан ардын аж амьдралыг сайжруулах талаар хийж байгаа дорвитой ажил байхгүй байна. Тэднийг нутгийн бусад иргэдийн адил хэмжээнд авч үздэг болохоос үндэсний цөөнх, устаж үгүй болох гэж байгаа эмзэг талаас нь тодорхойлж гаргасан бодлого шийдвэр байхгүй ажээ. Харин ч олон нийтийн дунд тэднийг залхуу, архичин, бэлэнчлэх сэтгэлгээтэй гэх мэтээр хандах буруу үзэл хандлага түгээмэл байна.



Цаатан хүүхэд, цаа бугын хамт

1996, 2001 онуудад аймгийн Засаг дарга Цагааннуур суманд очиж, цаатан иргэдтэй уулзаж байжээ. 2003 оны 6-р сард цаатны төлөөлөгчид Улаанбаатарт ирж төрийн түшээдэд өөрсдийн санал хүсэлтээ уламжилсны дагуу шат шатандаа үүрэг өгч Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Цагааннуур суманд 2 өдөр ажиллаж, тэдний хэрэгцээг судалж, амьдрал байдалтай нь танилцжээ. Энэ дагуу Хөвсгөл аймгийн Засаг даргаас Монгол улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт нийт 7 зүйлийг багтаасан цаатан ардуудын хэрэгцээт зүйлийг хүсэлт болгон тавьжээ. Үүнд:

1. Тувагаас 40 цаа бугыг авчрах
2. Радио хүлээн авагч 50ш
3. Сансрын антеннтай, нарны гэрлийн үүсгүүртэй телевиз 1ш
4. Багийн эмчийн бүрдэл цүнх, аппаратын хамт 1ш
5. "Цаачин" хоршоонд 5 сая төгрөг
6. Фургон автомашин 1ш
7. Цааны 2 эмчийн цалин 1,7 сая төгрөг

Засгийн газарт тавьсан дээрх хүсэлтэнд цасны моторт цана 3ш, богино долгионы радио станц 2ш, хэт богино долгионы радио станц 20ш, хэт богино долгионы радио станцыг холбогч дахин дамжуулах эфитер 2ш зэрэг зүйлсийг оруулаагүй хасжээ. Баруун болон зүүн тайгын өрхүүд ихэвчлэн тус тусдаа явдаг тул 2 тайгад тус бүрд нь 1 холбоо байгаа нь тэдний хэрэгцээг хангаж чадахгүй байгаагийн улмаас дээрх хүсэлтийг анх тавьжээ. Энэхүү тусламж нь нэг удаагийн шинжтэй байгаа бөгөөд цаатны амьдрал ахуйг өөд татаж, амьжиргааг нэмэгдүүлэх, цөөнхийнх нь хувьд юу хийх нь тодорхойгүй хэвээр байна. Хөвсгөл аймгийн хувьд Цагааннуур сум бол цөөн хүн амтай, хоёр багтай, хамгийн жижиг сум. Гэсэн хэдий ч үндэсний цөөнх амьдардаг онцлогийг харгалзан үзсэн бодлого баримталж иржээ. Жижиг сумыг хэвээр нь үлдээж явах нь сумын төсвийг батлахаас эхлээд л хүндрэл учирдаг тухай аймгийн удирдлагууд ярьж байсан. Хөвсгөл аймгийн ИТХ-аар “Хөвсгөл аймгийг бүсчилэн хөгжүүлэх бодлого /2002-2020/” баталжээ. Тус хөтөлбөрт туссанаар Цагааннуур сум аялал жуулчлалын бүсэд хамаарсан байна. Тус бодлогын баримт бичигт “...Цагааннуур суманд бусад сумдад байдаг орон тоо бүгд ажиллаж, 1 хүнд удирдлагын зардал 14,5, төсвийн зарлага 56,4, төсвийн орлого 5,3 мянган төгрөг оногдож байхад ... хамгийн олон хүн амтай Мөрөн суманд 1 хүнд оногдох удирдлагын зардал 2,3, төсвийн зарлага 38,2, орлого 7,4 мянган төгрөг байна...Энэ нь бүсчилсэн хөгжлийн эдийн засаг, санхүүгийн бүтцийг боловсронгуй болгох шаардлагатай болсныг харуулж байгаа нэг жишээ...”¹² хэмээн бичжээ. Дээрх бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхдээ үндэсний цөөнх амьдардаг сумын онцлогийг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай.

Сумын ИТХ-аас Цагааннуур сумыг 2002-2020 он хүртэл тогтвортой хөгжүүлэх зорилт, төлөвлөгөөгөө 2002 онд баталжээ. Тус төлөвлөгөөнд цаанд үржил селекцийн асуудлаар онцгой анхаарч уламжлалт өвөрмөц аж ахуйг өсгөх эрүүлжүүлэх, үндэсний цөөнхийн талаарх бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж, улс, аймгийн хүн ам зүйн бодлогод онцлон тусгуулах зэрэг зүйлийг тусгажээ.

Хөвсгөл аймгийн хэмжээнд болон Цагааннуур суманд үндэсний цөөнхийн онцлогийг тусгасан хөтөлбөр, арга хэмжээ байхгүй байна. Аймгийн Засаг Даргын Тамгын Газраас 1997 онд цаатны аж байдлыг сайжруулах чиглэлээр “Цаатан” төсөл бичиж байсан боловч санхүүжилт олдоогүйн улмаас одоог хүртэл хэрэгжсэнгүй. Хөвсгөл аймагт малжуулах

¹² Хөвсгөл аймгийг бүсчилэн хөгжүүлэх бодлого, 9-р тал, 2002 он

төсөл хэрэгжиж байгаа хэдий ч энэ нь цаатан иргэдэд хүртэх боломжгүй ажээ. Малжуулах төслийн хүмүүс цаа бугын эмчилгээнд зориулж эм тариа өгөх гэх мэт тусалцааг л үзүүлэх боломжтой юм байна.

2.2.3 Төрийн бус байгууллага болон олон улсын байгууллага, хувь хүтүүсээс авч хэрэгжүүлж байгаа арга хэтжээ

“Цаа буга сан” (1999), “Цаатан нийгэмлэг” (1997), “Тайгын байгаль нийгэмлэг” (2001) зэрэг төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Цаатны аж амьдралыг сайжруулах, цаа бугыг эрүүлжүүлэх чиглэлээр хэрэгжиж байгаа гадны төсөл бол “ТОТЕМ” төсөл юм. Дээрх ТББ-ууд нь олон улсын хандивлагч байгууллагуудын анхаарлыг цаатан иргэдэд чиглүүлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд нилээд үр дүнтэй ажиллаж байна.

Тухайлбал “Цаа буга” сан Цагааннуур сумын дунд сургуулийг шинээр бариулах санхүүжилтийг олж, бариулсан, сургуульд нь багш, сурагчийн ширээ бэлэглэсэн, тайгад хүрэх замыг сайжруулах зорилгоор 2 гүүр бариулсан, бүх өрхөд урцаа бүрэх брезент бэлэглэсэн, баруун тайгын айл бүрт уналганы морь өгөх болон хоёр тайгын хүмүүст хүнсний бүтээгдэхүүн, хувцас олгох, цаатан хүүхдүүдийг их дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлэх зэрэг тусламжыг 1997 оноос эхлэн үзүүлж байна. Мөн “Канад сан”, “Тотем” төсөлтэй хамтран цаа бугыг эрүүлжүүлэх чиглэлээр нилээд зүйл хийжээ. Цаатнуудад зарим хандивлагчдын анхаарлыг хандуулсны дүнд “Сантис” төвөөс баруун тайгынхныг унаажуулах, гар урлал, сийлбэрийн сургалт хийсэн, цаатан айлын нэг хүүхдийг өөрсдийн зардлаар АНУ-д эмчилгээнд явуулсан зэрэг ажлыг зохион байгуулжээ.

“Тайгын байгаль нийгэмлэг” ТББ нь цаатан ардуудын төлөөлөгчдийг Улаанбаатарт авчирч төр, засгийн удирдлагуудтай уулзуулж, арга хэмжээ зохион байгуулсан нь социализмаас хойш тэд анх удаагаа өөрсдөө дуу хоолойгоо төрийн түшээддээ хүргэх алтан боломжийг олгожээ. Үүний дүнд сум, аймгийн удирдлагууд зарим арга хэмжээг авч, тэдний аж байдлыг дээшлүүлэх талаар Засгийн газарт хүсэлт гаргаад байна.

Цаа бугыг эрүүлжүүлэх, тоо толгойг нь өсгөхөд төрийн бус байгууллагууд их хүчин зүтгэл гаргаж ажиллаж байгаа нь үнэхээр сайшаалтай байна.

БҮЛЭГ III. ЦААТАН ИРГЭДИЙН ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХИЙН ЭРХ БОЛОН БУСАД ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

3.1 Үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт

3.1.1 Өөрийн соёл иргэншилээ хадгалан үлдэх эрх

Цаатан ардууд нь 3-4 метрийн урттай, том ури бол 28-32, жижиг ури бол 17-23 мод орсон, брезентээр бүрсэн уламжлалт сууцандаа цельсийн нэмэх 31 хэмээс цельсийн хасах 53 хэм хүртэлх цаг уурын нөхцөлд өнөөг хүртэл амьдарсаар байна. Өмнө нь ангийн болон цаа бугын арьс, модны холтосоор урцаа бүрдэг байсан бол 1970-аад оноос судалгаа явуулж байж, бүх урцыг брезентээр бүрэх болжээ.




Эртний үед хэрэглэж байсан ури



Одоо цагт хэрэглэж буй ури

Цаатан иргэдийн өөрийн соёл иргэншлийн гол онцлог баталгаа нь цаа бугатай салшгүй холбоотой. Гэтэл сүүлийн жилүүдэд цаа буга эрс хорогдсон нь тайгад амьдарч байгаа цаатан иргэдийг талд бууж ирж, өөрсдийн уламжлалт амьдралын, өвөрмөц хэв маягаасаа татгалзахад хвөгэж байна.

Цагааннуур сумын цаа бугын тоо /1986-2002/



Социализмын үеийн цаатангуудыг төвлөрүүлж суурьшуулах гэсэн оролдлого нь цаатангуудын амьдралын хэв маяг, уламжлалтай зөрчилдөж, улмаар тайгыг эзгүйрүүлэхэд хүргэж байсан бол өнөөдөр тэдэнд чиглэсэн ямар ч бодлого, зорилтгүй байгаа нь арга хэмжээгүй явж ирсэн нь энэ өвөрмөц амьдралын хэв шинжийг аяндаа мөхөж алга болох аюул хүргэхээр байна.

Тайгад амьдарч байгаа цаатан иргэд өлөн зөлмүүн байдалд, дутагдаж гачигдах нөхцөлд амьдарч, оршин тогтнож байна. Цаатан ардуудын бусдаас онцгойрон харагддаг зан заншлын гол зүйлс гэвэл:

- гэр бүл болох /хуримлах, бэр буулгах/
- нас барагсдаа оршуулах /хүүхэд оршуулах/
- цаа сэтэрлэх
- ан авд мордох /онцолбол баавгай агнах/
- урц гэрээ барих
- нүүж суух зэрэг төрөхөөс эхлээд жам ёсоор хорвоог орхих үе хүртэл

амьдралын хугацаанд давтах үйлүүд болно. Цаатан ардуудын амьдралын хэв хэвшил дотор эртний овгийн байгууллын үеийн улбаа өнөө хэр хадгалагдсаар ирснийг тэдний зан үйлийг судалдаг гадаад дотоодын эрдэмтэд ажиглан мэдээлж байна. Тухайлбал, 2002 онд зүүн тайгын 10 өрхөд хийсэн судалгаагаар тэд хүнсээ /махаа/ ав адилхан хуваан авч, яг нэг өдөр хүнсээ дуусгаж байгаа жишээ болно. Мөн нас барагсдаа оршуулах зан үйлэнд ч их эртний хэв шинж хадгалагдаж байгаа юм. Цаатан ардуудын эд өлөг, хувцас хэрэглэл, гоёл чимэглэл, эдийн соёлын бүхий л өв уламжлал нь өнөөдөр бараг бүрэн устан үгүй болж байна. Тэд орчин үеийн шаардлагаар арьсан гутал, богцноосоо аажим салж байгаа шигээ хэл соёл, зан заншлаа мөн бөхөөн орхиж байна.



Уламжлалт өлгийдөө хүүхдээ өлгийдсэн байгаа нь

Социализмын үед орон нутгийг судлах музей байгуулсан байсан нь цаатан ардуудын соёл заншлыг олон нийтэд сурталчлах, ирээдүй хойч үедээ энэ өвөрмөц амьдрал, зан заншлыг хадгалан үлдээхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болжээ. Гэвч одоо энэ музей хаагдаж, дотор нь байсан зарим үнэт үзмэрүүд байхгүй болсон тухай анх энэ музейг байгуулсан Цагааннуурын Загасны үйлдвэрийн дарга Батаа гуай ярьж байсан.

3.1.2 Өөрийн шашин шүтэх эрх

Цаатан ардууд нь бөөгийн шашин шүтсээр ирсэн. Социализмын үед бөө буух, удган зайран тодруулах нь хязгаарлагдмал байсан ч тэд шашин соёлоо хадгалсаар ирсэн юм. “Цаатан бөө нь дархад бөөгийн мөргөлтэй агуулга хэлбэрээрээ бараг адил. Гэхдээ эртний шинж, агуулга ёс дэглэмийг нэлээд хадгалсан, буддын шашны нөлөөнд ороогүй өвөрмөц шинжтэй байна”¹³ гэж С.Бадамхатан тэмдэглэжээ.

Өнөөдөр баруун тайгад үе дамжсан онгодын эзэн 100 орчим настай Сууяан удган энх тунх амьдарч байна. Сууяан удган “Дархад бөөгийн талаар хийгдсэн судалгааны ажил нилээд байдаг хэдий ч цаатан бөө бол сайн судлагдаагүй байгаа юм” хэмээн хэлж байсан.

Судалгааны явцад цаатан ардуудын өрх бүр урц гэрийн хойморт эцэг дээдсийн нь сүнс сүлд шингэсэн онгод шүтээнээ залсан байсан. Харин нэг овог удмын цаатангууд өөр өөрийн тахиж шүтдэг онгон газар байдаг бөгөөд жилд 1-2 удаа очиж тахиж шүтэх ёс байдаг ажээ. Бидэнтэй уулзаж байсан улсын аварга цаачин Дагжий “Эцэг дээдсийн маань онгон Улаан-Уул сумын нутаг дахь хилийн зурваст ойрхон байдаг. Энэ онгон шүтээндээ очиход хилийн зөвшөөрөл авах гэж Улаан-Уул сум орох...Зөвшөөрөл өгөх хүмүүс нь байхгүй байх...Зөвшөөрөлгүй очоод тахиж шүтэх гэхээр хил зөрчигч хэмээн сэрдэгдэх гэх мэт бэрхшээл учирдаг тухайгаа ярьж байсан...” Өөр бусдаар бол өнөөдөр цаатан ардуудад итгэл үнэмшилтэй байх, өөрийн шашин шүтэх эрх нь зөрчигдөх, үүнээсээ үүдэж ялгаварлагдах явдал гардаггүй юм байна.

3.1.3 Төрөлх хэлээрээ ярих эрх

Цаатангууд тува, монгол хэлээр ярьдаг. Сумын дунд сургуульд тува хэлтэй боловсон хүчинг бодлоготойгоор бэлтгэж байсан. Одоогийн байдлаар цэцэрлэгийн багш 2, бага ангийн багш 2, дунд ангид хичээл заах тува хэл-уран зохиолын багш 1 бэлтгэгдсэн бөгөөд тэдгээрээс 3 нь сумынхаа сургуульд бага ангийн багшаар ажиллаж байна. Мөн тус

¹³ С.Бадамхатан, Хөвсгөлийн цаатан угсаатан, 1960 он, 37 дахь тал

сургуульд Тувагаас мэргэжилтэн багш нар урьж тува хэлний хичээл орж байсан. Тухайн үед цаатан хүүхдүүдэд тува хэл бичиг зааж байсан энэ сайхан уламжлал одоо алдагджээ. Өнөөдөр цаатан хүүхдүүдэд үндэстнийх нь хэл бичиг заах цөөн ч гэсэн мэргэжлийн багш байгаа ч орон нутгийнхны хайхрамжгүй байдал сургуулийн захиргааны хөөцөлдлөг дутагдсанаас болоод хичээлийн хөтөлбөрөөс хасагдсан байна.

Цаатан ардууд өнөөгийн байдлаар тува хэлээ зөвхөн хоорондын харилцааны түвшинд л эзэмшсэн, ялангуяа хүүхдүүд тува хэлээр энгийн хэдэн үгээс цааш мэддэггүй байна. Дунд сургуульд тува хэлийг үзэхгүй байгаа нь төрөлх хэлээ мартахад хүргэж буйд ахмад хүмүүс сэтгэл нь ихэд эмзэглэж явдаг ажээ. Хэсэг цаатан ардын төлөөлөгчид төр засгийн удирдлагууддаа эх хэлийг нь дунд сургуулийн сурагчдад оруулдаг болгохоор хүсэлт уламжлаад байгаа бөгөөд УИХ-ын гишүүн Т.Ганди 2005 оноос тува хэлийг Цагааннуур сумын сургуульд заалгах боломжтой тухай хариу өгчээ.

3.2 Цаатан иргэдийн эдийн засаг, нийгэм, соёл, иргэний, улс төрийн эрхийн төлөв байдал


3.2.1 Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн хэрэгжилт

Хөдөлмөрийн чадвартай 272 хүний 58 буюу 21,2% нь ажилгүй. Зөвхөн 6,6% нь л төсөвт байгууллагад ажиллаж байгаа бөгөөд үлдсэн хүмүүс нь цаачин, малчин зэрэг ажил хөдөлмөр эрхэлж байна. Өмнөх тогтолцооны үед загас, агнуурын аж ахуйд олон цаатан ажиллаж, амьдрал ахуйгаа хангаж байсан. 1956 онд Цагааннуурын загасны үйлдвэр байгуулж анх 30-аад цаатан иргэдийг элсүүлж зохих материал, техник-орчноор хангаж байсан байна. Гэтэл сүүлийн жилүүдэд төрөөс, орон нутгаас үндэстний цөөнх болсон дээрх иргэдэд чиглэсэн арга хэмжээ явуулахгүй болсон, цааны тоо толгой үлэмж хорогдсон зэрэг нь тэднийг ядууруулж байна. 1999 онд “Цаа буга сан”-гаас “Цаачин” хоршоог байгуулж өгсөн боловч эргэлтийн хөрөнгө байхгүйн улмаас одоог хүртэл тодорхой ажил хийгдээгүй байна.

3.2.2 Сурч боловсрох эрх

Цаатан иргэдийн боловсролын түвшин нилээд доогуур байна. Тайгад тусгай дунд боловсролтой хүн хамгийн өндөр боловсролтойд тооцогддог. Тэдний дунд бага боловсролтой гэх боловч бичиг үсэг мэдэхгүй хүн тааралдаж байна. Дээд боловсролтой гэх хэдэн цаатан нь Цагааннуур сумын төвд амьдардаг. Бидний анкетын асуулга авсан цаатан иргэдийн дотор бүрэн бус дунд болон бага боловсролтой хүмүүс 64,8%-ийг эзэлж байсан.

Цаатан иргэдийн боловсролын түвшин



2002 оны 1-р сарын 25-ны мэдээ,
Тайгын багийн Засаг дарга Буянтогтох

Цагааннуур сумын 8 жилийн дунд сургууль нь 322 сурагчтай бөгөөд тэнд 93 цаатан иргэдийн хүүхэд суралцаж байгаа нь нийт суралцагчдын 28.3 хувийг эзэлж байна. Үүнээс 28 сурагч тайгаас бусад 65 нь сумын төв болон тал нутагт мал маллан амьдарч байгаа цаатан гаралтай тува иргэдийн хүүхэд байна. Баруун, зүүн тайгад 0-16 насны 102 хүүхэд амьдарч байгаагаас сургуулийн насны бараг бүх эрэгтэй хүүхдүүд сургууль завсардан тайгадаа амьдарч байна. Тэнд томчуулыг даган цаа маллаж, ан авд мордож, тайгын хүнд хүчир бүхнийг туулж давахын зэрэгцээ, тамхи татах, архи уух зэрэг элдэв муу зуршилд эрт татагдан орж байна. Тайгад амьдарч байгаа 8-16 хүртэл насны нийт хүүхдээс 17 хүүхэд буюу 39.5 хувь нь сургууль завсардсан байна. "1997 онд сургуулийн насны цаатан хүүхэд 78 байгаагийн тал илүү хувь нь хувцас хунар, хоол унд, ном дэвтэргүйгээс сургуулийн хаалга татах хувь дутаж . . ." байсан /эх сурвалж; М.Нямаа, "Тайгын гүнд хаягдсан цаатан, цаа хоёр", Ардын эрх сонин, 1997.5.12./ тэр үетэй харьцуулахад сургууль завсардалт 10 гаран хувиар буурсан байна. Энэ нь дараах тоон баримтаар баталгаажиг байна.

Цаатан иргэдийн хүүхдүүдийн сургуульд элсэлт сүүлийн 5 жилээр:

Хүснэгт 2

Элсэлтийн он	1999-2000 он	2000-2001 он	2001-2002 он	2002-2003 он	2003-2004 он
Тоо	8	8	14	21	14
Хувь	21.6	19.5	34.1	32.3	22.2

Цаатан иргэдийн хүүхдүүдийн 8-р анги төгсөлт сүүлийн 3 жилээр:

Хүснэгт 3

Төгссөн он	2000-2001 он	2001-2002 он	2002-2003 он	Нийт
Тоо	3	6	13	22
Хувь	27.2	42.8	46.4	38.8

Цаатан иргэдийн хүүхдүүдийн 9-р анги д элсэлтийн байдал сүүлийн 3 жилээр:

Дэвшин суралцсан он	2000-2001 он	2001-2002он	2002-2003 он	Нийт
Тоо	3	3	9	15
Хувь	100	50	69.2	73.0

/эх сурвалж; Цагааннуур сумын 8 жилийн дунд сургуулийн сургалтын менежер С.Дөшнөө, нийгмийн ажилтан М.Эрдэнэбат нарын хийсэн судалгаанаас/

Цаатан хүүхдийн оюуны чадвар, сурах арга барил, стандарт эзэмшилт-сурлагын чанар бусад хүүхэд, үе тэнгийнхэнтэйгээ адил байдаг. Гэвч сургуульд ортлоо тайгад амьдарч байгаад ирсэн хүүхдүүдийн хувьд хэл ярианы хөгжил муутай, монгол хэлээр ойлгох, илэрхийлэх чадвар сул байдаг нь тэдний сурах идэвх, сонирхол, сурлагын үзүүлэлтэд нөлөөлдөг. Цаатан хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломжгүй, сургуульд ортлоо тува, монгол хэлээр хольж ярьдаг орчинд амьдардаг. Тэд дээрх хоёр хэлний аль алинаар нь ойр зуурын хэрэглээний түвшний мэдлэгтэй сургуульд орж ирдэг байна. Сурч боловсрох эрхийг хангах баталгаа нь багшлах боловсон хүчний хүрэлцээ хангамж, сургалтын орчин юм.

Цагааннуур сумын дунд сургууль нь 1998 онд шатсан бөгөөд “Цаа буга сан” төрийн бус байгууллагын санаачилга, хөрөнгө оруулалтаар баригдсан шинэ байранд 2000 оны 4-р сараас хичээллэх болсон. Гэвч сургуулийн номын сан байхгүй, сургуулийн байр болон дотуур байр нь гэрэл цахилгаангүй зэрэг нь сургалтын чанарт таагүй нөлөөлдөг. Сургуулийн дотуур байранд 65 хүүхдэд өгсөн төсвөөр 100-гаад хүүхэд хооллодог. Тухайлбал, 2003 оны 1-р сард аймгийн Боловсрол соёлын газраас хийсэн хяналт шинжилгээгээр тус сургууль дараах үнэлгээг үзүүлж аймгийнхаа хэмжээнд сүүлээсээ 4-р байранд орсон байна.

№	Үнэлсэн үзүүлэлт	Цуглуулах оноо	Цуглуулсан оноо
1.	Удирдлагын үйл ажиллагаа, зохион байгуулалт	7	4.14
2.	Сургалтын материаллаг болон бусад нөхцөл	5	2.88
3.	Багш ажилтны бүрэлдэхүүн, чанар	6.5	3.7
4.	Сургалтын чанар, үнэлэмж	10.5	3.7

/эх сурвалж; Хөвсгөл айлгийн ЕБС-уудын хяналт шинжилгээний дүн. Нэгтгэсэн; БСГ-ын арга зүйч М.Хишигхүү/

Тус сургуулийн бага ангийн багш нараас сүүлийн 5 жилд 4 багш аймгийн төвд богино хугацааны сургалтад хамрагдсаны 3 нь 5 жилийн өмнө, 1 нь 2003-2004 оны хичээлийн жилийн 11-р сард хамрагджээ. Тус сургуулийн удирдлагын зүгээс төсөв, санхүүг хэмнэх нэрээр багш нарыг

сурагчдын амралтаар цалингүй амрадаг зэрэг хөдөлмөрийн харилцааны зөрчил гардаг нь багш нарын бүтээлч үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байна. /Цагааннуур сумын бага ангийн багш нартай хийсэн ярилцлагаас/ Цагааннуур сумын дунд сургуульд нийтдээ цаатан гаралтай 5 бага ангийн багш ажиллаж байна.



Баруун тайгад амьдардаг цаатан хүүхдүүд

Сумын сургуулийн сургалтын чанар хангалтгүй байгаа нь тус сургуулийн сурагчид дээд шатны боловсрол эзэмшихэд сөргөөр нөлөөлдөг. Улаанбаатар хотод сурч байгаа цаатан оюутнуудтай хийсэн бүлгийн ярилцлагын үеэр тэдэнд тохиолддог бэрхшээлийг сонсоход 9-10-р ангид дэвшин суралцахаас эхлээд сурсан мэдсэн зүйл нь их гологддог, үүний улмаас их дээд сургуульд орсон ч гэсэн чанартай сайн сургалттай газар сурч чаддаггүй. Нэгэнт магадлан итгэмжлэл аваагүй сургуульд элссэн тохиолдолд сургалтын төлбөрийн хөнгөлөлт, зээл олдоггүй. “Цаа буга сан” гэх мэт байгууллага, хувь хүмүүсээс сургалтын төлбөрөө төлүүлээд сурах гэхээр энд амьдрах байр, хоол, хичээлийн хэрэгсэл авах мөнгө гэх мэт байнга бэрхшээл тохиолддог. Улаанбаатарт ямар нэгэн хамаатан садан байдаггүй учир хүүхдүүд 1-2 жил сураад сургуулиа орхиж нутаг буцахад хүрдэг хэмээн ярьж байсан.

3.2.3 Эрүүл тэндээ хатгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх

Тайгын цаг агаарын хүйтэн, сэрүүн уур амьсгалаас хамаарч цаатангуудын дунд өвчлөлт элбэг байдаг. Хамгийн түгээмэл хэлбэрийн өвчлөлт бол цусны даралт ихсэх, нүдний өвчлөлт, үе мөч болон хоолойны ангины юм. Өвөл, хавар, намрын улиралд хүйтнээс хамаарч өвчлөлт ихэсдэг энэ үеэр эмнэлгийн тусламж авахад хүндрэл байнга тохиолддог. Учир нь зам 40-60 см-ын цасаар хучигддаг тул зам хаагддаг.

Эмнэлгийн тусламж авах нөхцөл, боломжийг үзүүлбэл:

Газрын нэр	Улирал	Сумын төвөөс	Очих унааны боломж			Эмнэлгийн тусламж авах боломж
			Морь	Цаа	Машин	
Зүүн тайга	Өвөл	35-40	+	+	+	өдөртөө
	Зун	50	+	-	-	2 хоног
Баруун тайга	Өвөл	50	-	+	+	4 хоног
	Зун	50	+	+	+	2 хоног

Анкетын судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн ЭМД-ын талаарх мэдлэг, ойлголт туйлын хангалтгүй байсан. Тэднээс ЭМД-тай эсэхийг асуухад ЭМД-ын дэвтэртэй эсэхээ хэлэхээс биш, даатгалын хураамж төлсөн зүйл байхгүй байсан. Судалгааны явцад тэдний даатгалын дэвтрийг үзэхийг хүссэн боловч ихэнхэд нь байхгүй, сумын төвд байгаа гэж хариулж байсан. Энэ чиглэлээр сумын албан тушаалтнууд эмнэлгийн эмч, ажилтнууд тодорхой ажил хийх хэрэгтэйг харуулж байсан. Сайн дурын даатгалд хамрагддаг хүмүүсийн хувьд төлбөрийн чадваргүйгээс үүдээд эрүүл мэндийн даатгалгүй.

Мөн түүнчлэн түргэн тусламж дуудахад шатахууны мөнгийг авдаг талаар судалгаанд хамрагдсан иргэдийн 13 хүн буюу 35% нь ярьж байлаа. Түлшний мөнгийг эргүүлж төлнө гэж авдаг ч буцааж өгдөггүй ажээ. Нийт өрхийн 70% нь ядуу, нэн ядуу байдалд амьдарч байгаа, тэр дундаа сумын төвөөс алслагдсан эдгээр иргэдийн хувьд энэ байдал нь маш хүндээр тусч байна. Тайгад өвчлөхөд тэр бүр сумын төв орж эмнэлэгт үзүүлээд байх боломжгүй, эм тариа байхгүй зэргээс үүдээд олон бэрхшээл тохиолддог талаар ярьцгааж байсан. Энэ оны 7-р сард их эмч тайгад очиж үзлэг хийсэн. Цаатан иргэд эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэгт хамрагддаггүй. Харин Францын эмч мэргэжилтнүүд энэ зун очиж цаатангуудыг эмнэлгийн үзлэгт хамруулж, эм тариа өгчээ. Цаатан ардууд эрт цагаас тайгад ургадаг ховор эмийн ургамал, ан амьтны эд эрхтэнг хэрэглэх замаар өөрсдийгөө эмчлэх нарийн ухаантай байжээ. Тухайлбал хоолой өвдөхөд булганы цөс долоох, уушигны өвчтэй хүн вансэмбэрүү хэрэглэх гэх мэтээр ярьж байлаа. Гэвч мөн л энэ уламжлал нь нилээд алдагдаж, зарим нарийн ширийн зүйлээ мэдэх хүн үгүй болж эхэлжээ.

3.2.4 Эд мөнгөний тусламж авах эрх

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дунд нийгмийн халамж, даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийн хэрэгжилт хэвийн түвшинд байгаа боловч сэтгэцийн өөрчлөлттэй зарим хүн тэтгэвэр, тэтгэмж авдаггүй байна. Зарим нэг цаатан иргэд өмнө нь нэгдэлд ажиллаж байсан хөдөлмөрийн дэвтрээ хаяж үрэгдүүлсний улмаас тэтгэвэрээ хөөцөлдөж

авахад хүндрэл учраад байгаа тухай ярьж байсан. Аймгийн төвөөсөө алслагдсан тул тэр бүр тэтгэврээ хөөцөлдөж явж чаддаггүй ажээ. 2002 оны 5-р сард гаргасан дүнгээр тайгад амьдардаг цаатан өрхүүдийн 14 буюу 33% нь нэн ядуу, мөн 16 буюу 38% нь ядуу нөхцөлд амьдарч байна. Үүнийг Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын бүсэд хамаарч байгаа 7 сум, 1 тосгоны ядуурлын үзүүлэлттэй харьцуулахад ядуу өрх 16,7%, нэн ядуу өрх 6,3%-аар илүү байгаа нь цаатан иргэдийн амьдрал илүү хүнд байгааг давхар нотолж байна.

Нийгмийн халамжийн сангаас тэдэнд үзүүлэх тусламж хангалтгүй, тэднийг ядуурлаас бууруулах хөтөлбөр, төлөвлөгөө байдаггүй. Цаатангууд малтай бол амьжиргааны түвшин дээшилж болох тухай бас ярьж байсан. Гэтэл малжуулах төслийн хувьд 10-20 бодтой тэнцэх хэмжээний малтай айлд л мал өгдөг тул цаатангууд хамрагддаггүй. Ийм хэмжээний малтай цаатан өрх үнэндээ ганц нэгээс хэтрэхгүй байна. Сүүлийн жилүүдэд төрийн бус байгууллага, гадаадын иргэд, олон улсын байгууллага гэх мэт газруудаас тэдэнд тусалцаа үзүүлэх болсон. Гэвч ихэнх тусламж нэг удаагийн шинжтэй байгаа нь үр нөлөөг нь бууруулахад хүргэж байна. Сум орон нутгийн удирдлагуудын хайхрамжгүй хандлага ч энэ байдалд нөлөөлдөг. Тусламжын үр дүнг тооцож, тэдний хэрэгцээг тодорхойлсон судалгаа байхгүй байна.

3.2.5 Улс төрийн болон хувийн эрх

Судалгаанд оролцсон цаатангуудын 86% нь иргэний үнэмлэхтэй гэж байсан ч гаргаад үзүүлэх хүн тун ховор байсан. Харин 5 хүн иргэний үнэмлэхний төлбөр 2500 төгрөгөө багийн өмнөх Засаг даргадаа өгсөн боловч мөнгийг нь алдаж, хэсэг хугацааны дараа эргүүлэн өгсөн ч одоогийн зөрүүг төлөх боломжгүй тул үнэмлэхээ авч чадахгүй байгаагаа хэлж байсан.

Цаатан иргэд бүгд сонгуульд оролцдог гэж байсан хэдий ч хэний төлөө саналаа өгсөн юуны учир сонгуульд оролцдог талаарх тэдний мэдлэг, ойлголт туйлын хангалтгүй байна. Тэд мэдээллээр байнга дутагдаж байдаг тул цуу яриа, найз нөхдийнхөө, эцэг эхийнхээ дэмжиж байгаа хүнд санал өгдөг дагах хандлага гэдгийгээ хэлж байсан. Орон нутгийн хурал, захиргааны байгууллагад цаатан иргэдийн төлөөлөл байдаггүй. Гэтэл одоо Жошим нуур, нуурын орчмын газрыг хувьчилж авахаар 3 иргэн өргөдлөө өгөөд байгаа ажээ. Энэ нуур нь цаа бугын намрын гол бэлчээр учраас энэ нуурыг хувьчилахдаа цаатан ардуудын санаа бодлыг оруулж, шийдвэр гаргахгүй бол тэднийг хүнд байдалд оруулж болзошгүй.

Судалгаанд оролцсон иргэдийн 48,6% буюу 18 иргэн төрийн байгууллагад хүсэлт тавьж байснаас 6 хүний хүсэлтийг шийдвэрлэж өгчээ. Ихэвчлэн иргэний үнэмлэхний асуудал, цаа бугын цус сэлбэх, сумын төвтэй радио холбоотой болох гэх мэт асуудлаар хандаж байжээ.

Цаатан иргэдийн хувьд гэмт хэрэгт холбогдоод шүүхээр таслан шийдвэрлүүлсэн тохиолдол 1980-аад онд 1 гарсан бөгөөд, захиргааны хэрэг, зөрчилд холбогдох явдал мэр сэр гардаг. Тэднийг малын хулгайд сэрдэх, хилийн зөрчил гаргасан гэх мэт явдал байдаг.

Хувийн эрх чөлөөтэй холбоотой зарим мэдээллийг дурьдвал:

1. 51 настай, эрэгтэй: "...Баруун тайгад амьдардаг нэг иргэн бууныхаа татаварыг жил бүр 5000 төгрөг төлсөөр байхад, миний бууг хурааж аваад, 50000 төгрөг төл, төлөхгүй бол өгөхгүй гэсэн..."
2. 44 настай, эмэгтэй: "...Цагааннуур сумын цагдаагаар ажиллаж байсан Базаррагчаа ...дэлгүүрт хүний юм хулгайлсан хэмээн 1 өдөржингөө гавтай байлгасан..."
3. 34 настай, эмэгтэй: "...Миний ахыг 1970-аад оны үед цагдаагийн байгууллага хууль бусаар шалгаж байсан..."

Анкетын асуулгад хариулсан хүмүүсийн ярианаас...

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ДУГНЭЛТ

Цаатан иргэдийн амьдрал өнөөдөр маш хүнд байна. Тодорхой бодлого хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэхгүй, одоогийнх шиг байх аваас үндэсний цөөнхийн гол шинжээ алдаж, тайгад олон зуун жилийг туулсан нэн эртний нэгэн амьдралын өвөрмөц хэв шинж мөхөхөд хүрч байгаа нь үнэхээр эмгэнэлт явдал юм. Цаатангуудын хувьд өөрсдийн бичмэл түүх байхгүй, уламжлалт зан заншил нь баларч үгүй болсон, хүүхэд залуучууд нь өөрийн төрөлх хэлээ муу мэддэг, эсхүл мэдэхгүй болж, ахуй амьдралын хувьд ядууралд автсан зэрэг нь үүний гол шалтгаан болно.

Цаатан иргэдийн хэрэгцээг тодорхойлох, тусламжын явцад хяналт тавих, үр дүнг үнэлэх зэрэгт сум орон нутгийн захиргааны байгууллагуудын үүргийг өндөржүүлэх шаардлагатай байна. Цагааннуур сум бол үндэсний цөөнх амьдарч байгаа гэдгээрээ онцлогтой сум юм. Тиймээс дараах арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

- Цөөнхийн хувьд тэдний өөрсдийн соёл, амьдралын өвөрмөц хэв шинжээ хадгалан үлдэх гэсэн хүсэл эрмэлзлэлийг нь хөхиүлэн дэмжиж, энэ чиглэлээр тусламж, дэмжлэг үзүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Цагааннуур сумын 8 жилийн сургуульд тува хэлийг заахгүй байгаа нь тэдний төрөлх хэлээрээ сурах, өвлөн авах эрхийг нь ноцтойгоор зөрчиж байгаа тул сургалтын хөтөлбөрт нь оруулах;
- Цаа бугыг эрүүлжүүлэх, тоо толгойг өсгөх, үржил селекцийн ажлыг зохион байгуулахад зориуд анхаарч, нэн яаралтай арга хэмжээ авах;
- Малжуулах, ядуурлыг бууруулах төсөлд цаатангуудыг хамруулж, орлогоо нэмэгдүүлэх, улмаар амьдралын наад захын хэрэгцээгээ хангахад чиглэсэн тусламж дэмжлэгийг үзүүлэх;
- Цаатан иргэдийг дээд боловсрол эзэмшихэд нь төрөөс дэмжлэг үзүүлэх;



МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИСС
ЗӨВЛӨМЖ

211236 Улаанбаатар хот / Чөлөөтэй дүүрэг /
Эрх мөлийн талбай / Засагийн газрын XI байр /
Телефон: 31-65-09, 31-65-08, 31-02-64 / Факс: 31-61-08
E-mail: konstantin@nec.gov.mn / Адрес: www.nec.gov.mn

2004. 3.08 № 03

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИТХТ-ИЙН ДАРГА
Б.НАРАНТУЯА, ЗАСАГ ДАРГА
Л.ДАМДИНСҮРЭН, ЦАГААНУУР
СУМЫН ИТХТ-ИЙН ДАРГА Н.ДОРЛИГ,
ЗАСАГ ДАРГА Я.ЭРДЭНЭЖАВ
НАР ТАНАА

Цаатан иргэдийн тухай

Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2003 оны 10-12 дугаар сарын хооронд Цагаануур сумын нутаг дэвсгэрт амьдарч, аж төрж буй үндэсний цөөнх болох цаатан иргэдийн эрхийн төлөв байдалд судалгаа хийсэн юм.

Үндэсний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд ихээхэн бага бөгөөд хэл, соёл, шашин шүтлэгийнхээ хувьд ялгарах, өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзлэл бүхий тодорхой бүлэг хүмүүсийг хэлдэг.

Комиссоос цаатангуудын эрхийн асуудлыг судлахдаа соёлоо хадгалж үлдэх, өөрийн шашныг шүтэх, төрөлх хэлээрээ ярих, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхээ хэрхэн эдэлж чадаж буйд онцлон анхаарсан болно

Судалгаанд Цагаануур сумын нутаг дахь баруун, зүүн тайгад амьдарч байгаа цаатан иргэд, сумын дунд сургуульд суралцаж буй сурагчид, мал малладаг болон сумын төвд амьдардаг цаатан иргэд, багш, түүнчлэн Улаанбаатар хотод их, дээд сургуулиудад сурч буй цаатан гарлын оюутнуудыг хамруулсан. Мөрөн ба Цагаануур сумын Засаг даргын Тамгын газар, холбогдох хэлтэс, албад дээр цаатангуудын талаар гаргасан шийдвэр, хүн амын болон малын тоо бүртгэл зэрэг баримт бичгийн судалгаа хийв. Судалгааны ажлын явцад цаатан иргэдэд чиглэсэн арга хэмжээ, хөтөлбөр, төслүүдтэй танилцаж, мэргэжлийн судлаачид, эрдэмтдийн санал, зөвлөгөөг анхааран үзсэн болно.

Судалгааны явцад анзаарагдсан зарим зүйлийг товч танилцуулбал:

- 1990-ээд оноос хойш цаатангуудын амьдрал эрс хүндэрч, цаагаа нядлах, цааны зэрээ худалдах, гадаад дотоодын жуулчдад цаагаа унуулах зэргээр алдаг оног орлого олж, өнөө маргаашаа аргацаах байдалд шилжжээ. Сүүлийн жилүүдэд цааны өвчин ихэсч, цаа бугын үржил селекцийн бодлого үгүй болж, цаанууд жижгэрч давжаарсаар байна.
- Тайгад буй нийт ерхийн 33 хувь нь /14 өрх/ нэн ядуу, 38 хувь нь /15 өрх/ ядуу нөхцөлд амьдарч байна.
- Хөдөлмөрийн чадвартай цаатан иргэдийн 58 хувь нь эрхэлсэн ажилгүй.
- Цаатангууд тува, монгол хэлээр ярьдаг боловч цаатан хүүхдүүдэд өөрийнх нь төрөлх хэлийг дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрийн хүрээнд заадаггүй байна. Цаатан хүүхдүүд тува хэлийг энгийн хэдэн үгнээс цааш мэдэхгүй байгаа нь төрөлх хэлээ мартах, орхиод хүргэнэ гэж ахмад үеийнхэн нь санаа зовж буй нь бүрэн үндэслэлтэй юм.

- Цагааннуур сумын 8 жилийн дунд сургуульд цаатан 93 хүүхэд суралцаж буй нь нийт суралцагчдын 28.3 хувийг эзэлж байна. Үүний 28 сурагч нь тайгаас, бусад 65 нь сумын төв болон мал маллагч цаатан иргэдийн хүүхэд ажээ. Баруун, зүүн тайгад 8-16 насны 17 хүүхэд сургууль завсардсан байгаа нь сургуульд хамрагдавал зохих нийт хүүхдийн 39.5 хувь болж байна. Цаг агаарын хүйтэн, сэрүүн уур амьсгалаас үүдэлтэйгээр цаатангуудын дунд өвчлөлт их байна. Хамгийн түгээмэл өвчин бол цусны даралт ихсэх, нүдний өвчин, үе мөч болон хоолойн ангины юм. Өвөл, хавар, намрын улиралд эмнэлгийн тусламж авахад байнгын хүндрэл, бэрхшээл гардаг. Эмнэлгийн түргэн тусламж дуудахад шатахууны /түлшний/ мөнгийг авдаг нь ихээхэн хүндрэл учруулдаг байна.
- Нэн ядуу, ядуу амьдралтай цаатан иргэд, өрхөд нийгмийн халамжийн сангаас үзүүлэх тусламж дэмжлэг хангалтгүй, ядуурлаас гаргах, ядуурлын түвшинг бууруулах хөтөлбөр, бодлого байхгүй байгаа нь хуульд заасан тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхээ эдэлж чадахгүйд хүргэж байна.
- Цаатан иргэдэд болж буй үйл явдлын талаархи үнэн бодит мэдээлэл тэр бүр хүрдэггүй байна. Орон нутгийн хуралд цаатан иргэдийн төлөөлөл байдаггүй.

Цаатангуудын аж амьдрал, эрхийн байдлыг дээшлүүлэх талаархи бодлого, үйл ажиллагаандаа дараах арга хэмжээнүүдийг анхааран үзэж авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

1. Цагааннуур сум бол манай улс дахь хамгийн өвөрмөц, хамгийн бага тоотой үндэсний цөөнх амьдарч буйгаар онцлог юм. Үндэсний цөөнх нь төрөлх хэл, соёл, шашин уламжлал, өхүй амьдралын хэв шинжээ өвлөн хадгалах, төрөлх хэлээрээ сурч боловсрох, улс орныхоо нийгэм, улс төр, соёл, эдийн засгийн амьдралд идэвхитэй оролцох онцгой эрхийг олон улс нийтээр хүлээн зөвшөөрсөн. Энэхүү онцгой эрх нь ямар нэг давуу эрх биш бөгөөд цөөнх өөрийнхөө өвөрмөц хэв шинж, онцлог, уламжлалаа хадгалан үлдэх боломж, арга хэрэгсэл нь болдог байна. Иймээс цаатан иргэдийн дээрх эрхийг бүх талаар хэрэгжүүлж, хөхиүлэн дэмжих шаардлагатай байна.
2. Малжуулах, ядуурлыг бууруулах төсөлд цаатангуудыг хамруулж, аж төрөх орлогын байнгын эх үүсвэртэй болгоход чиглэсэн тусламж, дэмжлэгийг үзүүлэх.
3. Цагааннуур суманд цаатан иргэдэд зориулсан ажлын байр бий болгох. "Цаачин" хоршоог дэмжих.
4. Цаатан иргэдэд тусламж үзүүлдэг гадаад, дотоодын байгууллага, хөтөлбөр, төсөл, хувь хүмүүстэй үр бүтээлтэй хамтран ажиллах.
5. Тайгын байгалийг хамгаалах төсөл, хөтөлбөрийг дэмжиж, хэрэгжүүлэх.
6. Тайгад очих жуулчны сүлжээ, маршрут, үйлчилгээг хөгжүүлж, үүнийг цаатангуудын орлогыг нэмэгдүүлэх чухал эх үүсвэр болгох.
7. Цааны сүүг эмчилгээний журмаар ашиглах, бугын ясан эвэр болон арьсаар гар урлал, чимэглэлийн эд зүйлс хийх, борлуулах, сурталчлах төсөл, үйл ажиллагааг дэмжих.
8. Цаа бугын удмын санг хамгаалах, эрүүлжүүлэх, тоо толгойг өсгөх ажлыг мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор зохион байгуулах.
9. Цагааннуур сумын дунд сургуульд суралцаж буй цаатан хүүхдүүдэд эх хэлийг нь заах.
10. Сумын ИТХ-д цаатны төлөөллийг оруулах.
11. Тайгын иргэдэд мэдээлэл хүлээн авах боломжийг бий болгох.
12. Аймгийн статистик мэдээнд цаатан иргэд, цаа бугатай холбоотой мэдээллийг оруулах.

ДАРГА

С. ЦЭРЭНДОРЖ

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССООС СУДАЛГААНЫ МӨРӨӨР АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

НҮБ-ын ХЭДКГ-ын санхүүжилтээр хийгдсэн судалгааны ажлын тайланд үндэслэн Комисс Хөвсгөл аймаг, Цагааннуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Дарга, Засаг дарга нарт цаатан иргэдийн эрхийн хэрэгжилтийг сайжруулах тухай зөвлөмжийг хүргүүлсэн билээ. Энэхүү зөвлөмжид Цагааннуур сумын ИТХ-д цаатан иргэдийн төлөөллийг оруулах тухай асуудал багтсан байсан бөгөөд 2004 оны орон нутгийн сонгуулиар Цэцэгмаа, Ядам, Гүнд зэрэг цаатны төлөөлөл сумын ИТХ-д сонгогдсон байна. Энэ нь цаатан иргэдийн эрх ашгийг орон нутгийн өөрийн удирдлагын гаргаж буй шийдвэрт тусгуулах, энэ чиглэлээр дорвитой ажил зохион байгуулахад гарсан томоохон амжилт мөн билээ.

Комисс зөвлөмж явуулахаас гадна цаатан иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тодорхой ажлууд төлөвлөж, Канад сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд:

1. Хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих чиглэлээр “Үндэстний цөөнх ба Хүний эрх” сэдвийн хүрээнд аймаг, сумын ИТХ, ЗДТГ-ын ажилтнуудад тус бүр 2 өдрийн сургалт, сумын иргэд, ТББ-ын төлөөлөгчдөд “Хүний эрхийн үр нөлөөтэй хамгааллыг хэрхэн зохион байгуулах вэ”, “Төсөл хэрхэн бичих вэ” зэрэг сэдвээр мөн 2 өдрийн сургалт зохион байгуулсан. Түүнчлэн цаатан иргэдэд хүний эрхийн тодорхой асуудлыг багтаасан гарын авлагыг бэлтгэж, түгээх ажлыг зохион байгуулаа. Энэ чиглэлээр 3 төрлийн гарын авлагыг бэлтгэж, түгээхээр ажиллаж байна.
2. Үндэстний цөөнхийн эрхийн талаар цөөнх өөрсдөө мэдэхээс гадна, олонх энэ талаар тодорхой ойлголт, мэдлэгтэй, хүндэтгэдэг байж тэдний эрх бүрэн хангагдаж хамгаалагдах нөхцөл бүрэлдэх билээ. Тиймээс “Миний мэдэх үндэстний цөөнх” зохион бичлэгийн уралдааныг дунд сургуулийн сурагчдын дунд, “Үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт” эссе бичлэгийн уралдааныг насанд хүрэгчдийн дунд үндэстний хэмжээнд зохион байгуулсан. Нөгөө талаараа энэ арга хэмжээ нь үндэстний цөөнхийн талаар олон нийтийн санаа бодлыг сонсох, цаашид энэ чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах зорилготой байсан. Нэн тэргүүнд тус уралдаанд эхний байр

эээлсэн бүтээлүүдийг улирал тутам Комиссоос эрхлэн гаргадаг “Хүний эрх” сэтгүүлийн 2-р улирлын дугаарт гаргасан болно. Мөн түүнчлэн үндэстний цөөнхийн эрхийн талаар ТВ-ийн нэвтрүүлгийг бэлтгэн, цаахаар ажиллаж байна.

3. Судалгааны явцад иргэний үнэмлэхээ шинээр авч чадаагүй ядуу, нэн ядуу өрхийн цаатан иргэд нилээд их байсан. Тиймээс Цагааннуур сумын багийн Засаг дарга нарын гаргасан судалгааны дагуу нийт 44 хүнд иргэний үнэмлэх олгуулж, 66 хүний иргэний үнэмлэхний зургийг авахуулах ажлыг зохион байгуулсан.
4. Судалгаагаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан цаатан иргэд бараг байхгүй байсан тул Комиссоос санаачлан цаатан иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Энэ үзлэгийн онцлог нь оношлогооны аппаратыг тэдний амьдарч байгаа газар нь буюу тайгад хүргэж үйлчилснээрээ онцлогтой юм. Энэхүү үзлэгт давхардсан тоогоор 417 хүн хамрагдсан.
5. Цагааннуур сумын 8 жилийн сургуулийн номын сан шатаж, номын фонд байхгүй болсон бөгөөд ном хандивлах ажлыг зарим ТББ, олон улсын байгууллагаас үзүүлсэн хэдий ч хангалттай хэмжээний номын фонд байхгүй байсан тул Комиссоос Монголын уран зохиолын дээжис, Л.Түдэвийн 25 боть болон танин мэдэхүйн чиглэлийн 100 орчим номыг сумын найман жилийн сургуульд хандивласан. Энэ нь тус сумын нийт иргэдэд оюуны хөрөнгө оруулалт болж байгаагаараа ач холбогдолтой байлаа.
6. Энэ ажлын хүрээнд 2005 оны 10-р сард Улаанбаатар хотноо үндэсний хэмжээний бага хурлыг хийхээр төлөвлөөд байна. Үүний зорилго нь цаатан иргэдийн өмнө тулгамдаад байгаа асуудалд олон нийт, төр засаг, олон улсын болон аялал жуулчлалын байгууллагуудын анхаарлыг хандуулах зорилготой юм.

УИХ-ЫН
СУДАЛГААНЫ САН